

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ТАЙЛАН  
/БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН ГАЗАР/**

2023.12.07-ний өдөр

Баян-Өндөр сум

Шийдвэрийн дэс дугаар	Зүйл, заалтын дэс дугаар	Шийдвэрийн нэр, огноо, дугаар, агуулга	Биелэлт	Үнэлгээ, (хүчингүй болсон, хяналтаас хасуулах тухай санал)	Тасарсан болон удааширч байгаа шалтгаан
1	2	3	4	5	6
<b>Салбар чиглэл: Биеийн тамир, спортын газар</b>					
<b>1.а. Монгол Улсын хууль</b>					
1	8.1.2. Харьяа нутаг дэвсгэртээ иргэнийг идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэх.	Биеийн тамир, спортын тухай хууль  /шинэчилсэн найруулга/  2017 оны 07 дугаар сарын 06-ний өдөр	<p>Аймгийн хэмжээнд цэнгэлдэх хүрээлэн 1, спорт заал 35, амралт чөлөөт цагийн талбай 122, Усан бассейн 2, Цанын бааз 1, Мөсөн гулгуурын талбай 4, дугуйн зам 2, явган алхалтын зам 3 байдаг нь иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх таатай орчин нөхцөлөөр хангах боломжийг бүрдүүлж байна. Үүнээс: Их дээд 2 сургуулийн 2 нь, Ерөнхий боловсролын 16 сургуулийн 19 хичээлийн байранд спорт заалтай сургууль 19, хувийн хэвшлийн 5 сургуулийн 2 сургууль нь спорт заалтай байна. Стандартын шаардлага хангасан биеийн тамирын гадна талбайтай 10 сургууль үүнээс 15-р сургууль хөлбөмбөгийн 2 талбайтай.</p> <p>Тайлант онд орон нутгийн төсвийн 1,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар Зэст багт спорт заалны барилгын ажлын гүйцэтгэл 100 хувь, мөн орон нутгийн төсвийн 1 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар унадаг дугуйн замын ажлын гүйцэтгэл 40 хувь, орон нутгийн 741,4 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар амралт, чөлөөт цагийн 8 талбай, биеийн тамирын 1 талбайн барилгын ажил 100 хувийн гүйцэтгэлтэй ашиглалтад орж спорт заал 1-ээр, амралт,</p>	100%	

			<p>чөлөөт цагийн талбай 8-аар, биеийн тамирын талбай 1-ээр тус тус нэмэгдсэн.</p> <p>Биеийн тамир, спортын зориулалттай заал, зам, талбайд төрийн болон төрийн бус 46 байгууллагуудтай хамтран ажиллаж, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн 160 арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 40013 иргэн, спортын 37 төрлөөр 420 удаагийн тэмцээн уралдаан зохион байгуулж, давхардсан тоогоор 51450 иргэнийг тус тус хамруулсан.Томоохон арга хэмжээнээс дурьдвал:</p> <p>-Улсын аварга шалгаруулах тэмцээн 7, бүсийн аварга шалгаруулах тэмцээн 3 тус тус зохион байгуулж ажилласан нь өмнөх оноос улсын аварга шалгаруулах тэмцээнийг 1-ээр нэмэгдүүлж, нийт 3635 тамирчдыг оролцуулан зохион байгуулсан. Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын дагуу “Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадам”, “Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадам”-г Орхон аймаг амжилттай зохион байгуулсан. Тус наадмуудад 13 аймаг, 7 дүүргийн нийт 760 тамирчид 526 багц медалийн төлөө хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн.Наадмын хүрээнд зохион байгуулагдсан тэмцээний зам талбайг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-н хөрөнгө оруулалтаар Сархиа чийрэгжүүлэх хэсэгт өвлийн спортын снөүбоард, уулын цана, гүйлтийн цанын замыг тавьж тэмцээнийг уралдааныг зохион байгуулсан.Мөн улс болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Эрдэнэт спорт амралтын хүрээлэн”-д гүйлтийн тэшүүр, шорт трекийн уралдааны зам талбай шинээр тавьж тэмцээн уралдааныг зохион байгуулсан.</p> <p>-Хичээллэе-Өрнүүлэе-Хэвшье” аян болон “Эрүүл Монгол хүн” аяны хүрээнд “Нэг анги Нэг өглөө”, Уурхайн хот-100 км, Найрамдал дружба “Эрүүл мэнд гороо” алхалт, “Нээлттэй хаалганы өдөрлөг”, өглөөний дасгал, ажлын байрны дасгал зэрэг арга хэмжээг 26 спорт заал, биеийн тамирын чийрэгжүүлэх танхим болон амралт, чөлөөт цагийн талбайд зохион байгуулж, давхардсан тоогоор 18231 иргэнийг хамруулсан.</p>		
--	--	--	--	--	--

		<p>-Аймгийн хэмжээнд 14 фитнес клуб тогтмол үйл ажиллагаа явуулдаг. Үүнээс 3 клуб нь магадлан итгэмжлэгдсэн.Тайлант онд фитнес клуб 1-ээр, хичээллэгчдийн тоог 100-аар нэмэгдүүлж, өдөрт 1900 иргэн тогтмол хичээллэж байна.</p> <p>-Баян-Өндөр, Сархиа ууланд зуны улиралд явган алхалтын замд өдөр бүр 600-900 иргэн тогтмол алхаж, гүйн дасгал хөдөлгөөнд,</p> <p>-“Эрдэнэт спорт амралтын хүрээлэн”-д мөсөн шагай мөсөн сурын спортоор 110 иргэн, зуны улиралд үндэсний сур-120, үндэсний бөхийн спортоор 130 тамирчид бэлтгэл сургуулилтаа тогтмол хийж байна.</p> <p>-“Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн”-д хөл бөмбөг, сагсан бөмбөг, гар бөмбөгийн гадна талбай, алхалт, дугуйн 1.2 км зам бүхий замд урин дулааны цагт өдөрт 1000-1500 иргэн, өвлийн улиралд 300-500 иргэн тогтмол үйлчлүүлж байна.</p>		
	8.1.4. Суманд орон тооны арга зүйч ажиллуулах.	Баян-Өндөр суманд биеийн тамирын арга зүйч ажиллуулж, Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спорт улсын хорооноос зохион байгуулсан 2 удаагийн сургалтад хамруулж мэргэшүүлсэн. Жаргалант суманд биеийн тамирын арга зүйч ажиллуулах орон тоо, цалин хөлс шийдвэрлэгдээгүй байна.	50%	
	8.1.5. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах, хэрэгжилтийг хангах.	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 01-р сарын 08-ны 03 тогтоолоор “Өвлийн спортыг хөгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр”-ийг 4 үндсэн зорилтын хүрээнд 16 арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахаар батлагдсанаас 2023 онд 13 арга хэмжээг 100 хувь, 2 арга хэмжээ 70 хувиар, 1 арга хэмжээг 40 хувиар тус тус хэрэгжүүлж, хөтөлбөрийг 92,5 хувиар хэрэгжүүлж ажилласан.	92.5%	
	8.1.6. Хүн амын нягтаршил, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн иргэний идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх боломжийг бий болгох, спортын барилга байгууламж, заал талбайн хүрэлцээ, хангамжийг нэмэгдүүлэх, бэхжүүлэх.	<p>Аймгийн хэмжээнд цэнгэлдэх хүрээлэн 1, спорт заал 35, амралт чөлөөт цагийн талбай 122, Усан бассейн 2, Цанын бааз 1, Мөсөн гулгуурын талбай 4, дугуйн зам 2, явган алхалтын зам 3 байдаг нь иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх таатай орчин нөхцөлөөр хангах боломжийг бүрдүүлж байна.</p> <p>Тайлант онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар спорт заал 1-ээр, амралт, чөлөөт цагийн талбай 8-аар, дугуйн зам 1-ээр, биеийн тамирын талбай 1-ээр тус тус нэмэгдсэн.</p>	100%	

			<p>-Төрийн болон төрийн өмчит байгууллагууд, ерөнхий боловсролын сургуулиудад 34 спорт заал үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд орон нутгийн төсвийн 1,2 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар спорт заал 1-ээр нэмэгдэж 35 спорт заалтай болж, аймгийн 1 хүнд ногдох спорт заалны хүртээмжийн индекс 2022 онд 0.13м<sup>2</sup> байсан бол 2023 онд 0.15м<sup>2</sup> болж өмнөх оноос 0.02м<sup>2</sup> –иар нэмэгдсэн. Мөн тайлант онд улс, төр, хувийн түншлэлийн хөрөнгө оруулалтаар спорт заал 4 баригдаж байна. Үүнд:</p> <p>-Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ерөнхий боловсролын 3-р сургуулийн 18x24 харьцаатай спорт заалны барилгын ажлын явц 30%;</p> <p>-Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ерөнхий боловсролын 8-р сургуулийн 18x24 харьцаатай спорт заалны барилгын ажлын явц 30%;</p> <p>-Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар ерөнхий боловсролын 16-р сургуулийн 18x24 харьцаатай спорт заалны барилгын ажлын явц 70%;</p> <p>-Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд Сансар худалдааны төвийн хажуу талд иргэн М.Мөнх-Амгалангийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй 18x24 харьцаатай спорт заал бүхий цогцолборын барилгын ажлын явц 70%;</p>		
2	8.1.7. Биеийн тамир, спортыг хөгжүүлэх чиглэлээр спортын холбоод, бусад байгууллагатай хамтран ажиллах.		Тайлант онд биеийн тамир, спортын 28 холбоо, клубтэй хамтран ажиллах гэрээ байгуулж улс, бүс, аймгийн аварга шалгаруулах болон нэрэмжит 82 тэмцээн, биеийн тамир чийрэгжилтийн 160 арга хэмжээг зохион байгуулахад улс, орон нутгийн төсвөөс 665,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажилласан.	100%	
	10.1.8. Биеийн тамир, спортын мэдээллийн нэгдсэн цахим санг бүрдүүлэх.		Тус байгууллагын Orkhon@sport.gov.mn веб сайтад тэмцээн уралдаантай холбогдолтой зурган мэдээлэл 30, байгууллагын ил тод байдлын тухай хууль, тогтоомж, даргын тушаал гэх мэт 15 гаруй мэдээллийг байршуулсан байна. Мөн иргэд олон нийтийг мэдээ мэдээллээр хангах зорилгоор аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж байгаа спортын болон нийтийг хамарсан арга хэмжээний мэдээллийг тогтмол оруулан ажиллаж байна.Мөн социал	100%	

			<p>сүлжээн дэх “Биеийн тамир, спортын газар” пэйж хуудсанд биеийн тамирын өдөрлөг, спортын мэдээ, мэдээлэл, статистик мэдээ, шилэн данс, ил тод байдал, хууль дүрэм, Монголын бүх ард түмний спортын XVI наадам, Монголын хүүхдийн спортын VII наадмын өвөл зуны төрлийн тэмцээний мэдээ мэдээлэл, наадмын цахим бүртгэл зэрэг 251 мэдээллийг нэгтгэн оруулж давхардсан тоогоор 45016 иргэний хандалт авсан байна.</p> <p>-Аймгийн хэвлэл мэдээлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж буй үйл ажиллагаа, мэдээлэл сурталчилгаа, цахим мэдээлэл, видео бичлэг, нэвтрүүлэг бэлтгэн иргэдийг мэдээллээр ханган цахим санг баяжуулж байна.</p>		
	<p>10.1.9. Хүн амд эрүүл аж төрөх зан үйлийг хэвшүүлэх, иргэнийг өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор идэвхтэй хөдөлгөөн, спортоор хичээллэх ажлыг зохион байгуулах.</p>		<p>Төрийн болон төрийн бус 46 байгууллагуудтай хамтран ажиллаж, биеийн тамир, чийрэгжүүлэлтийн 160 арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 40013 иргэнийг хамруулсан. Үүнээс: ахмад настны тэмцээн уралдаан 15, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн өдөрлөг, тэмцээн уралдаан 11, алхалт 4, өглөөний дасгал 33, үндэсний спортын тэмцээн 60, бусад арга хэмжээ 41 тус тус зохион байгуулж ажилласан.</p> <p>Спортын заал танхимд хамрагдсан хүний тоо:</p> <p>-“Нэг анги Нэг өглөө” арга хэмжээний өглөөний дасгалыг 11 сургуулийн 26 спорт заал, биеийн тамир чийрэгжүүлэлтийн танхимд 12632 сурагч, 2597 эцэг эх нийт 15229 иргэнийг дасгал хөдөлгөөнд хамруулсан.</p> <p>Гадаа талбайн тоо, хамрагдсан хүний тоо:</p> <p>-“Нэг анги Нэг өглөө” арга хэмжээний өглөөний дасгалыг Цагаанчулуут баг, Уртбулаг баг, Хүрэнбулаг баг Шанд, Даваат багийн ерөнхий боловсролын сургуулийн 700 гаруй сурагч, эцэг эхчүүд 5 гадна талбайд дасгал хөдөлгөөнөөр хичээллэсэн.Аймгийн хэмжээнд өдөрт дунджаар 450-600 иргэн тогтмол алхаж, гүйж байна. Аймгийн Явган алхалтын холбоотой хамтран Орхон аймагт 21 аймаг, 9 дүүргийн алхагч иргэдийн дунд 100 км-ийн уртын алхалтыг зохион байгуулж, 100 алхагч, Найрамдал дружба явган алхалтын арга</p>	<p>100%</p>	

			хэмжээг 16км-ийн зайнд зохион байгуулж, 45 алхагч иргэнийг хамруулсан. Мөн Эрдэнэт үйлдвэрийн болон бусад төрийн болон төрийн бус байгуулагын ажиллагсад ажил-гэр маршрутад 350-400 хүн тогтмол дугуй унаж байна.		
	10.1.10. Бие бялдрын түвшин тогтоох сорилыг улсын хэмжээнд зохион байгуулах ажлыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах.		Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигаар “Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ын арга хэмжээг аймгийн хэмжээнд тайлант оны 4-5 сард зохион байгуулж, сорилд хүн амын 9 хувь буюу 9631 иргэдийг хамруулснаас 56% нь А, В, С үнэлгээтэй байна. Үүнээс: А үнэлгээтэй 856, В үнэлгээтэй 2078, С үнэлгээтэй 3870, D үнэлгээтэй 1953, F үнэлгээтэй 874 иргэн тус тус байна. 2022 онд бие бялдрын чийрэгжилтийн түвшин тогтоох сорилын үнэлгээ D, F үнэлгээ хийгдсэн 1435 иргэн буюу таргалалтын 3-р зэрэгтэй хүнээс 268 иргэнийг эрүүлжүүлэх, хэвийн жинд оруулах зорилгоор “Жин хасах” уралдааныг зохион байгуулж, 60 иргэнийг хамруулсан. Мөн аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа фитнес клубуудад 208 иргэнийг хэвийн жинд оруулах, эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан.	100%	
Хэсгийн дундаж-92,8%					
1.г. Ерөнхийлөгчийн зарлиг					
3	1.Өвлийн спортыг хөгжүүлэх орчин үеийн шаардлага, стандартыг хангасан задгай болон битүү барилга байгууламжийн цогцолборыг нийслэл Улаанбаатар хот болон боломжтой бусад суурин газарт бариулах, зохих хөрөнгө оруулалтыг төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын	Ерөнхийлөгчийн зарлиг  2014 оны 03 дугаар сарын 04-ний өдөр  Дугаар 27  Засгийн газарт	Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 01-р сарын 08-ны 03 тогтоолоор “Өвлийн спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийн хүрээнд “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-н Хангарьд хоккейн клубээс битүү дээвэртэй мөсөн талбай бүхий хоккейн барилгын зургийг “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-н зураг төслийн цехээр хийлгэсэн. Барилга байгууламжийн төсвийн тооцоо хийгдэж байна.	40%	

	ажиллагаанд тулгуурлан шийдвэрлэх;	чиглэл өгөх тухай			
4	2. Ерөнхий мэргэжлийн болон дээд боловсролын байгууллагын хичээлийн сургалтын хөтөлбөрт өвлийн спортын төрлүүдээс тусган, өвлийн улиралд дадал болгон хэвшүүлэх, сурагч оюутны өвлийн спортоор хичээллэх таатай орчин нөхцөлөөр хангах, энэ чиглэлээр биеийн тамирын багш нарыг мэргэшүүлэх;		<p>Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2020 оны 01-р сарын 08-ны 03 тогтоолоор “Өвлийн спортыг хөгжүүлэх дэд хөтөлбөр”-ийг дэд хөтөлбөрийн хүрээнд дараах ажлуудыг зохион байгуулсан. Үүнд:</p> <p>-Спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын “Ирээдүйн-Одод” сургууль 2023-2024 оны хичээлийн жилд 6-12 ангийн нийт 7 бүлэгийн 168 сурагчдад тэшүүрийн хичээлийн хөтөлбөр хэрэгжүүлэхээр батлагдсан.</p> <p>-Биеийн тамир, спортын газарт гүйлтийн цанын секцэд 40, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-н Спорт цогцолборт уулын цанын секцэд 35 өсвөрийн тамирчин тус тус хичээллэж байна.</p> <p>-Ерөнхий боловсролын 15 дугаар сургуулийн гадна талбайд мөсөн талбай байгуулж байгаа бөгөөд биеийн тамирын хичээлийн хөтөлбөрт тэшүүрийн сургалт явуулахаар тусгагдсан.</p>	100%	
	4. Өвлийн спортын барилга байгууламжийн цогцолборт түшиглэн уралдаан, тэмцээн зохион байгуулах, Монгол Улсын тамирчид гадаад улсын баг, тамирчидтай бэлтгэл хийх, хамтран ажиллахыг хөхүүлэн дэмжих		<p>Монгол Улсын Засгийн газрын 2018 оны “Журам батлах тухай” 183 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам”-ын 2.1, 3.1-д зааснаар Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2022 оны “Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадам, Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадмыг 2023 онд зохион байгуулах эрх олгох тухай” А/208 дугаар тушаалын дагуу Биеийн тамир, спортын улсын хорооны дарга, Орхон аймгийн Засаг дарга нар 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Улаанбаатар хотод спортын наадмуудыг зохион байгуулах гэрээ байгуулсан.</p> <p>Дээрх гэрээний дагуу Орхон аймгийн Зохион байгуулах хороог аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн “Хороо байгуулах тухай” А/02 дугаар захирамжаар байгуулсан. Өвлийн наадмыг зохион байгуулах хороо наадмын бэлтгэл ажлын хангах, зохион байгуулалт хийх ерөнхий төлөвлөгөөг 5 үндсэн чиглэлээр 96 арга хэмжээг хэрэгжүүлж, нийт 5 удаагийн хурлаар 31 асуудлыг шийдвэрлэн бэлтгэл ажлыг хангасан.</p>	100%	

			<p>Орхон аймгийн зохион байгуулах хороо Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадам, Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадмыг 2023 оны 02 сарын 06-ны өдрөөс 2023 оны 02 сарын 13-ны өдрүүдэд “Нөхөрлөл-Тэмүүлэл-Амжилт” уриан дор амжилттай зохион байгуулсан. Биеийн тамир, спортын улсын хорооны баталсан өвлийн наадмын нэгдсэн зааврын дагуу үндсэн төрлөөр уулын цана, гүйлтийн цана, гүйлтийн тэшүүр, шорт трек, шайбтай хоккей, үзүүлэх тоглолтоор снөүбоардын төрөлд 13 аймаг, 7 дүүргийн нийт 760 тамирчид 526 багц медалийн төлөө хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн. Үүнд:</p> <p>-Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадмыг үндсэн төрлөөр гүйлтийн тэшүүр, шорт трек, гүйлтийн цана, уулын цана, шайбтай хоккей, үзүүлэх тоглолтоор снөүбоардын төрлөөр зохион байгуулсан. Тэмцээнд 8 аймаг, 7 дүүргийн 259 тамирчин, 17 дасгалжуулагч өрсөлдсөнөөс багийн дүнгээр:</p> <p>1-р байрыг “Алдар” спорт хороо 2-р байрыг Орхон аймаг 3-р байрыг “Хилчин” спорт хороо</p> <p>-Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадмыг үндсэн төрлөөр гүйлтийн тэшүүр, шорт трек, гүйлтийн цана, уулын цана, шайбтай хоккей, үзүүлэх тоглолтоор снөүбоардын төрлөөр зохион байгуулсан.Тэмцээнд 13 аймаг, 7 дүүргийн 490 тамирчин, 24 дасгалжуулагч өрсөлдсөнөөс багийн дүнгээр:</p> <p>-1-р байрыг Хөвсгөл аймаг -2-р байрыг Булган аймаг -3-р байрыг Төв аймаг</p> <p>Наадмыг зохион байгуулсанаар Орхон аймагт 1.036.526.200 төгрөг хөрөнгө оруулалт, худалдан авалт хийгдэж худалдаа үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжин ажилласан.</p>		
	1. Хүн амын орчин үеийн эрүүл хэв маяг, зан үйлд сургах, аливаа саад,		Монгол улсын Ерөнхийлөгчийн 2010 оны 53 дугаар зарлигаар “Хүн амын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ын арга хэмжээг аймгийн хэмжээнд тайлант оны 4-5 сард	100%	



5	<p>бэрхшээлийг даван туулах бие, сэтгэлийн тэсвэр хатуужилтай шинэ үеийг бий болгох зорилгоор “Хүн амын бие, бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшин тогтоох сорил”-ыг МУ-ын Ерөнхийлөгчийн санаачилгаар жил бүрийн 4 дүгээр сард явуулж байх</p>	Ерөнхийлөгчийн зарлиг	<p>зохион байгуулж, сорилд хүн амын 9 хувь буюу 9631 иргэдийг хамруулснаас 56% нь А, В, С үнэлгээтэй байна. Үүнээс: А үнэлгээтэй 856, В үнэлгээтэй 2078, С үнэлгээтэй 3870, D үнэлгээтэй 1953, F үнэлгээтэй 874 иргэн тус тус байна.</p> <p>2022 онд бие бялдрын чийрэгжилтийн түвшин тогтоох сорилын үнэлгээ D, F үнэлгээ хийгдсэн 1435 иргэн буюу таргалалтын 3-р зэрэгтэй хүнээс 268 иргэнийг эрүүлжүүлэх, хэвийн жинд оруулах зорилгоор “Жин хасах” уралдааныг зохион байгуулж, 60 иргэнийг хамруулсан. Мөн аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж байгаа фитнес клубуудад 208 иргэнийг хэвийн жинд оруулах, эрүүлжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулсан.</p>		
	<p>2. Биеийн тамир, спортыг нийтийн үйл хэрэг болгох зорилгоор дунд болон их, дээд сургуулиудад биеийн тамир, спортыг сургалтын тэргүүлэх чиглэл болгож, сурагч, оюутнуудыг спортоор хичээллэх таатай орчин нөхцөлөөр хангах, спортын хамтлаг клубын тогтолцоог нэвтрүүлж ажиллах</p>	<p>2010 оны 03 дугаар сарын 26-ны өдөр</p> <p>Дугаар 53</p> <p>Нийтийн биеийн тамир, спортыг хөгжүүлэх тухай</p>	<p>Аймгийн хэмжээнд цэнгэлдэх хүрээлэн 1, спорт заал 35, спортын гадна талбай 122, Усан бассейн 2, Цанын бааз 1, Мөсөн гулгуурын талбай 6 байдаг нь иргэдийг спортоор хичээллэх таатай орчин нөхцөлөөр хангах боломжийг бүрдүүлсэн.</p> <p>Үүнээс: Их дээд 3 сургуулийн 2 нь, Ерөнхий боловсролын 16 сургуулийн 20 хичээлийн байранд спорт заалтай сургууль 19, хувийн хэвшлийн 5 сургуулийн 2 сургууль нь спорт заалтай байна.</p> <p>Стандартын шаардлага хангасан биеийн тамирын гадна талбайтай 10 сургууль үүнээс 15-р сургууль хөлбөмбөгийн 2 талбайтай байна. Аймгийн хэмжээнд 14 фитнес клуб тогтмол үйл ажиллагаа явуулдаг. Үүнээс 3 клуб нь магадлан итгэмжлэгдсэн. Тайлант онд фитнес клубт хичээллэгчдийн тоог 100-өөр нэмэгдүүлж, 1900 иргэн тогтмол хичээллэж байна.</p> <p>Спортын заал, фитнес клубүүдийн төлбөрийн хувьд:</p> <ul style="list-style-type: none"> <li>➢ Спорт заалны 1 сарын төлбөр нь дунджаар 30,000 төгрөг</li> <li>➢ фитнес клубын 1 сарын төлбөр нь дунджаар 62,000 төгрөг байна.</li> </ul> <p>Иргэд хөдөлмөрчид, хүүхэд багачууд, оюутан сурагчдад биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулах, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, идэвхтэй хөдөлгөөнд хамруулах ажлын хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн 72 биеийн тамирын багш, спортын салбарын 50 гаруй арга зүйч мэргэжилтэн нар нийт 120 гаруй мэргэжлийн боловсон хүчин ажилладаг.</p>	100%	

			Аймгийн хэмжээнд төрийн болон төрийн бус байгууллага, спортын холбоо, клуб, хамтлагуудтай хамтран биеийн тамир чийрэгжүүлэлтийн 160 арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 40013 иргэнийг хамруулсан.		
6	1/Үндэсний болон хөл бөмбөг, хоккейн спортыг хөгжүүлэх орчин үеийн шаардлага, стандартыг хангасан барилга байгууламжийн цогцолборыг нийслэл Улаанбаатар хот болон боломжтой бусад суурин газарт бариулах, газрын асуудлыг шийдвэрлэх, дотоод гадаадын зохих хөрөнгө оруулалтыг төр, хувийн хэвшлийн түншлэл, хамтын ажиллагаанд тулгуурлан шийдвэрлэх;	Ерөнхийлөгчийн зарлиг  Дугаар 144  2015 оны 08 дугаар сарын 13-ны өдөр	Аймгийн хэмжээнд үндэсний сурын талбай 1, мөсөн шагай, сурын талбай 1, хөл бөмбөгийн зориулалттай талбай 10, хоккейн талбай 2, шагай харвааны бэлтгэлийн заал 1 тус тус ашиглагдаж тамирчид, хүүхэд, залуус чөлөөт цагаа өнгөрөөх, бэлтгэл сургуулилт тэмцээн уралдааныг тогтмол зохион байгуулж байна. Үндэсний спортын мөсөн шагай, мөсөн сурын талбайг “Эрдэнэт спорт амралтын хүрээлэн”-д 2022 оноос жил бүр байгуулж, бэлтгэл сургуулилт тэмцээн уралдаан зохион байгуулах боломж нөхцлийг бүрдүүлж ажилласан. Мөн үндэсний спортын сур харвааны талбайг Эрдэнэт спорт амралтын хүрээлэнгийн гадна байгуулж бэлтгэл сургуулилт, тэмцээн уралдааныг тогтмол зохион байгуулж байна.	100%	
	4/Үндэсний болон багийн спортын барилга байгууламжийн цогцолборт түшиглэсэн багийн спортын мэргэжлийн сургалттай академи бий болгох, спортын сургалттай дунд сургуульд тухайн чиглэлээр анги нээх, мэргэжлийн болон боловсролын байгууллагууд дэргэдээ үндэсний болон багийн спортын төрлүүдийг клуб	Засгийн газарт чиглэл өгөх тухай	Тайлант онд үндэсний спортын мөсний шагай, мөсөн сур харваа, үндэсний сур харваа, шагайн харваа, үндэсний бөхийн төрлүүдээр нийт 204 өсвөрийн тамирчин тогтмол хичээллэж байна. Үүнд: -Мөсний шагайн харваагаар өсвөр үеийн 42 тамирчин, Мөсний сур харвааны өсвөр үеийн 16 тамирчин “Эрдэнэт спорт амралтын хүрээлэн”-гийн мөсөн талбайд; -Үндэсний бөхийн 110 өсвөрийн бөхчүүд Биеийн тамир, спорт газрын Уурхайчин заалны бөхийн зааланд, ерөнхий боловсролын 13, 17, 18 сургуулийн секц дугуйланд; -Үндэсний сур харвааны 6 өсвөрийн тамирчин “Эрдэнэт спорт амралтын хүрээлэн”-гийн сурын талбайд бэлтгэл сургуулилтыг тогтмол хийж, сургалт арга зүйгээр Биеийн тамир спортын газар, спортын холбоодын дасгалжуулагч багш нар ханган ажиллаж байна.	100%	

	<p>хэлбэрээр зохион байгуулж ажиллах, уралдаан тэмцээн зохион байгуулах, Монгол Улсын тамирчид гадаад улсын баг тамирчидтай бэлтгэл хийх хамтран ажиллахыг хөхиүлэн дэмжих;</p>		<p>Багийн спортын төрлүүд болох хөл бөмбөг, сагсан бөмбөг, волейболын секц дугуйланд нийт 2100 өсвөрийн тамирчид бэлтгэл сургуулилт хийж, тэмцээн уралдаанд тогтмол оролцож байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> <li>-Волейболын спортоор 27 багш дасгалжуулагч, 2 клубын секц дугуйланд 930 өсвөрийн тамирчид;</li> <li>-Хөл бөмбөгийн спортоор 5 багш дасгалжуулагчийн секц дугуйланд 328 өсвөрийн тамирчид;</li> <li>-Сагсан бөмбөгийн 20 багш дасгалжуулагчийн секц дугуйланд 600 өсвөрийн тамирчид;</li> </ul> <p>Багийн спортын төрлүүдийг хөгжүүлэх зорилгоор спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын “Ирээдүйн-Одод” сургуульд сагсан бөмбөгийн ангид 25, волейболын ангид 90 хүүхэд тус тус хичээллэж байна.</p>		
7	<p>1.8.Иргэд, хүүхэд залуучуудын чөлөөт цагийг зөв боловсон өнгөрөөх, биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлэхэд зохион байгуулалт, хөрөнгө санхүүгийн дэмжлэг үзүүлж, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, байгууллагуудыг дэмжин хамтран ажиллах;</p>	<p>Ерөнхийлөгчийн зарлиг</p> <p>2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр</p> <p>Дугаар 43</p> <p>Засгийн газарт чиглэл өгөх тухай</p>	<p>Аймгийн хэмжээнд цэнгэлдэх хүрээлэн 1, спорт заал 35, амралт чөлөөт цагийн талбай 122, Усан бассейн 2, Цанын бааз 1, Мөсөн гулгуурын талбай 4, дугуйн зам 2, явган алхалтын зам 3 байдаг нь иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх таатай орчин нөхцөлөөр хангах боломжийг бүрдүүлж байна.</p> <p>Тайлант онд аймгийн хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх, дасгал хөдөлгөөн хийх орчин нөхцлийг бий болгох зорилгоор орон нутгийн төсвийн 741,4 сая төгрөгөөр амралт чөлөөт цагийн 8 талбайг шинээр, спорт заалны хүртээмжийг нэмэгдүүлэхэд орон нутгийн төсвийн 1,2 тэрбум төгрөгийн хөрөнгөөр 1 спорт заал, орон нутгийн төсвийн 1 тэр бум төгрөгийн хөрөнгөөр унадаг дугуйн 3,1 км зам, өвлийн спортыг хөгжүүлэхэд орон нутгийн төсвийн 184 сая төгрөгөөр техник тоног төхөөрөмж, өвлийн спортын зам талбайг тус тус барьж байгуулан биеийн тамир, спортын барилга байгууламжийг 1-ээр, зам, талбайг 10-аар тус тус нэмэгдүүлэн ажиллалаа. Аймгийн хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, ерөнхий боловсролын сургуулиудад спортын цогцолбор 1, спорт заал 35 үйл ажиллагаа явуулж байна. Биеийн тамир, спортын газрын А, Б заалны хэвийн үйл ажиллагааг хангаж урсгал зардалд орон нутгийн төсвөөс 488,4 сая төгрөгийг шийдвэрлэж ажиллалаа.</p>	100%	

			Тайлант онд биеийн тамир, спортын 28 холбоо клубтэй хамтран ажиллах гэрээ байгуулж улс, бүс, аймгийн аварга шалгаруулах болон нэрэмжит 82 тэмцээн, биеийн тамир чийрэгжилтийн 160 арга хэмжээг зохион байгуулахад улс, орон нутгийн төсвөөс 665,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажилласнаар Орхон аймагт 1 тэрбум, 300 сая төгрөгийн хөрөнгө оруулалт, худалдан авалт хийгдэж худалдаа үйлчилгээ эрхлэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлсэн.		
Хэсгийн дундаж-92,5%					
1.е.Засгийн газрын тогтоол					
8	Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм	2019 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Дугаар 33 Дүрэм батлах тухай	Байгууллагын даргын 2020 оны 02 дугаар сарын 17-ны өдрийн А/19 дүгээр тушаалаар байгууллагын “Байгууллагын ёс, зүйн зөвлөл”-ийг 3 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна. Зөвлөлийн гишүүд нь “Биеийн тамир, спортын газрын ёс зүйн зөвлөл”-ийн ажиллах журам, 2023 оны жилийн ажлын төлөвлөгөө боловсруулан байгууллагын даргаар батлуулан ажилласан. Төлөвлөгөөний дагуу ажилтан, албан хаагчдад “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”, байгууллагын ёс зүйн зөвлөлийн ажиллах журам болон УИХ-аас 2023 оны 05 сарын 04-ний өдөр батлагдсан “Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль”-ийг сурталчилж ажилласан. 2023 онд ажилтан, албан хаагчдын ёс зүй, харилцаа хандлагатай холбоотой зөрчил, гомдол ирээгүй.	100%	
9	1. Иргэд биеийн тамир, спортоор хичээллэхэд зориулан гүйлт, алхалтын зам, дасгал хөдөлгөөн хийх ногоон байгууламж бүхий ил талбай байгуулж, өвлийн улиралд байгалийн болон хиймэл мөс,цасан талбайг харъяа нутаг дэвсгэрийнхээ орон сууц, гэр хорооллын	Засгийн газрын тогтоол 2009 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр	Аймгийн хэмжээнд цэнгэлдэх хүрээлэн 1, спорт заал 35, амралт чөлөөт цагийн талбай 122, Усан бассейн 2, Цанын бааз 1, Мөсөн гулгуурын талбай 4, дугуйн зам 2, явган алхалтын зам 3 байдаг нь иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх таатай орчин нөхцөлөөр хангах боломжийг бүрдүүлж байна.Иргэд хөдөлмөрчид, хүүхэд багачууд, оюутан сурагчдад нийтийн биеийн тамир, спортын арга хэмжээг зохион байгуулах, тэдний чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх , идэвхтэй хөдөлгөөнд хамруулах ажлын хүрээнд биеийн тамир чийрэгжүүлэлтийн 160 арга хэмжээг зохион байгуулж, давхардсан тоогоор 40013 иргэнийг хамруулсан. Үүнд:	100%	

	орчимд байгуулж, тогтмол ажиллуулах.	Дугаар 5  Нийтийн биеийн тамир спортын талаар авах зарим арга хэмжээний тухай	<p>-Төрийн болон төрийн бус хувийн хэвшлийн спортын 34 зааланд уралдаан тэмцээн нийтийн биеийн тамирын арга хэмжээ тогтмол зохион байгуулагдаж байна. Ерөнхий боловсролын сургуулиудын дунд “Нэг анги-Нэг өглөө” дасгал арга хэмжээг зохион байгуулж өглөөний дасгалд 11 сургуулийн 26 спорт зааланд 2 сарын хугацаанд 12632 сурагч, 2597 эцэг эх нийт 15229 иргэнийг дасгал хөдөлгөөнд хамруулсан.</p> <p>-Баян-Өндөр уул, Сархиа уулын явган алхалтын замд өдөр бүр 600-900 иргэн тогтмол алхаж, гүйн дасгал хөдөлгөөнд идэвхтэй хамрагддаг.</p> <p>-Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг 14 фитнес клубтэй хамтарч ажилладаг ба фитнес клубуудэд 1 өдөрт давхардсан тоогоор 1900 иргэд үйлчлүүлж байна.</p> <p>-“Эрдэнэт спорт амралтын хүрээлэн”-д тэшүүрийн спортоор өвлийн улиралд 1200 иргэн, мөсөн шагай мөсөн сурын спортоор 286 иргэн, зуны улиралд үндэсний сур-120, үндэсний бөхийн спортоор 150 тамирчид бэлтгэл сургуулилтаа тогтмол хийж байна.</p> <p>-“Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэн”-д хөл бөмбөг, сагсан бөмбөг, гар бөмбөгийн гадна талбай, алхалт, дугуйн 1.2 км зам бүхий замд урин дулааны цагт өдөрт 1000-1500 иргэн, өвлийн улиралд 300-500 тогтмол үйлчлүүлж байна.</p> <p>-Амралт, чөлөөт цагийн нийт 122 талбай ашиглагдаж байна. Биеийн тамир, спортын газраас амралт чөлөөт цагийн 5 талбайд 700 гаруй иргэдийг дасгал хөдөлгөөнд, спортын 4 удаагийн тэмцээнд 760 гаруй тамирчдыг хамруулж ажиллалаа.</p>		
9	2. Биеийн тамир, спортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын санаачилгыг бүх талаар дэмжиж ажиллах.		<p>Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус 46 байгууллага, биеийн тамир, спортын 28 холбоо клуб, 14 фитнес клуб, 30 спортын хамтлагтай хамтран ажиллаж байна. Тайлант онд улс, бүс, аймгийн аварга шалгаруулах болон нэрэмжит 82 тэмцээн, биеийн тамир чийрэгжилтийн 160 арга хэмжээг зохион байгуулахад улс, орон нутгийн төсвөөс 665,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэг үзүүлэн ажилласан.</p>	100%	

10	3.Аймаг, нийслэл, дүүргийн биеийн тамир, спортын байгууллагын үйл ажиллагааг идэвхижүүлж, чадавхийг нь дээшлүүлэх арга хэмжээ авах		<p>Тайлант онд Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооноос аймгийн биеийн тамир спортын газрын хүний нөөцийг мэргэшүүлэх, техник тоног төхөөрөмжийг сайжруулахад хөрөнгө санхүүгийн туслалцааг үзүүлсэн. Үүнд:</p> <p>-Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооноос зохион байгуулсан 6 удаагийн туршлага судлах, мэргэшүүлэх, сургалт, уулзалт зөвлөгөөнд тус газрын давхардсан тоогоор 31 албан хаагч, Баян-Өндөр сумын Засаг даргын Тамгын газрын биеийн тамирын арга зүйч, мэргэжилтэн нарыг тус тус хамруулсан.</p> <p>-Засгийн газрын тохируулагч агентлаг Биеийн тамир, спортын улсын хорооноос улсын төсвийн 60,0 сая төгрөгийн компьютер, хэвлэх хувилах төхөөрөмж, тавилга эд хогшил, багаж тоног төхөөрөмжийн дэмжлэгийг тус тус үзүүлсэн.</p>	100%	
11	6.4. сумын соёл-спортын төв, аймаг, дүүргийн спортын ордонд иргэд биеийн тамир, спортоор хичээллэх, уралдаан тэмцээн зохион байгуулах таатай орчин бүрдүүлэх арга хэмжээ авах.		Тайлант онд орон нутгийн төсвийн 950,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар спортын төрөлжсөн сургалттай ерөнхий боловсролын “Ирээдүйн-Одод” сургуулийн спорт заалны өргөтгөл, инженерийн шугмын засвар үйлчилгээний ажил хийгдэж дууссан.	100%	
12	6.5. Улсын хэмжээнд ашиглагдаж байгаа нийтийн биеийн тамир, спортын заал, танхим, гадна талбайн ашиглалтыг сайжруулах, цаашид зориулалтыг өөрчлөх, бусдад		Аймгийн хэмжээнд цэнгэлдэх хүрээлэн 1, спорт заал 35, амралт чөлөөт цагийн талбай 122, Усан бассейн 2, Цанын бааз 1, Мөсөн гулгуурын талбай 4, дугуйн зам 2, явган алхалтын зам 3, амралтын чөлөөт цагийн 122 талбай байдаг нь иргэдийг биеийн тамир, спортоор хичээллэх таатай орчин нөхцөлөөр хангах боломжийг бүрдүүлж байна.	100%	

	шилжүүлэх, худалдахыг хориглох чиглэлээр тодорхой арга хэмжээ авах.		Тайлант онд ерөнхий боловсролын 5, 15, 18 дугаар сургуулийн биеийн тамирын талбайг орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр болон шинэчлэн засварласан. Мөн амралт, чөлөөт цагийн 8 талбайг орон нутгийн төсвийн 741,4 сая төгрөгөөр, спорт заалыг 1,2 тэрбум төгрөгөөр, унадаг дугуйн 3,1 км замыг 1 тэрбум төгрөгөөр тус тус барьж байгуулсан. Орон сууцны хороололд байрлах амралт чөлөөт цагийн болон биеийн тамирын талбайн эзэмшил ашиглалтыг аймгийн Хот тохижуулах газар, гэр хорооллын байршилд байгаа амралт чөлөөт цагийн болон биеийн тамирын талбайн эзэмшил ашиглалтыг Баян-Өндөр сумын ЗДТГ, ерөнхий боловсролын сургуулиудын биеийн тамирын талбайн эзэмшил ашиглалтыг тухайн сургууль нь тус тус хариуцан ажиллаж байна. Тайлант онд биеийн тамир, спортын газраас амралт, чөлөөт цагийн 5 талбайд 700 гаруй иргэдийг дасгал хөдөлгөөнд, спортын 4 удаагийн тэмцээнд 760 гаруй тамирчдыг хамруулж, гадаа талбайн ашиглалтыг сайжруулан ажиллалаа.		
13	Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам	Засгийн газрын тогтоол 2018 оны 06 дугаар сарын 20-ний өдөр Дугаар 183	Тайлант онд Засгийн газрын 2018 оны 183 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Улсын хэмжээний спортын наадам зохион байгуулах журам”-н 2.1.1, 2.1.2, 2.1.3-д заасан спортын наадмуудад Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2022 оны “Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадам, Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадмыг 2023 онд зохион байгуулах эрх олгох тухай” А/208 дугаар тушаалын дагуу Биеийн тамир, спортын улсын хорооны дарга, Орхон аймгийн Засаг дарга нар 2022 оны 12 дугаар сарын 22-ны өдөр Улаанбаатар хотод спортын наадмуудыг зохион байгуулах гэрээ байгуулсан. Дээрх гэрээний дагуу Орхон аймгийн Зохион байгуулах хороог аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн “Хороо байгуулах тухай” А/02 дугаар захирамжаар байгуулсан. Өвлийн наадмыг зохион байгуулах хороо наадмын бэлтгэл ажлын хангах, зохион байгуулалт хийх ерөнхий төлөвлөгөөг 5 үндсэн чиглэлээр 96 арга хэмжээг хэрэгжүүлж, нийт 5 удаагийн хурлаар 31 асуудлыг шийдвэрлэн бэлтгэл ажлыг хангасан.  Орхон аймгийн зохион байгуулах хороо Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадам, Монголын хүүхдийн спортын	100%	

		<p>өвлийн VII наадмыг 2023 оны 02 сарын 06-ны өдрөөс 2023 оны 02 сарын 13-ны өдрүүдэд “Нөхөрлөл-Тэмүүлэл-Амжилт” уриан дор амжилттай зохион байгуулсан. Биеийн тамир, спортын улсын хорооны баталсан өвлийн наадмын нэгдсэн зааврын дагуу үндсэн төрлөөр уулын цана, гүйлтийн цана, гүйлтийн тэшүүр, шорт трек, шайбтай хоккей, үзүүлэх тоглолтоор снөүбоардын төрөлд 13 аймаг, 7 дүүргийн нийт 760 тамирчид 526 багц медалийн төлөө хурд хүч, авхаалж самбаагаа сорин өрсөлдсөн.</p> <p>-Монголын бүх ард түмний спортын өвлийн XVI наадмыг үндсэн төрлөөр гүйлтийн тэшүүр, шорт трек, гүйлтийн цана, уулын цана, шайбтай хоккей, үзүүлэх тоглолтоор снөүбоардын төрлөөр зохион байгуулсан. Тэмцээнд 8 аймаг, 7 дүүргийн 259 тамирчин, 17 дасгалжуулагч өрсөлдсөнөөс багийн дүнгээр:</p> <p>1-р байрыг “Алдар” спорт хороо  2-р байрыг Орхон аймаг  3-р байрыг “Хилчин” спорт хороо</p> <p>-Монголын хүүхдийн спортын өвлийн VII наадмыг үндсэн төрлөөр гүйлтийн тэшүүр, шорт трек, гүйлтийн цана, уулын цана, шайбтай хоккей, үзүүлэх тоглолтоор снөүбоардын төрлөөр зохион байгуулсан.Тэмцээнд 13 аймаг, 7 дүүргийн 490 тамирчин, 24 дасгалжуулагч өрсөлдсөнөөс багийн дүнгээр:</p> <p>-1-р байрыг Хөвсгөл аймаг  -2-р байрыг Булган аймаг  -3-р байрыг Төв аймаг</p> <p>Наадмыг зохион байгуулсанаар Орхон аймагт 1.036.526.200 төгрөг хөрөнгө оруулалт, худалдан авалт хийгдэж аж ахуйн нэгж, байгууллагуудыг дэмжин ажилласан.</p>		
Хэсгийн дундаж -100%				
Нийт дундаж-95,1%				



